



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 1/98

Улаанбаатар хот

ГЗочид буудал, дэн буудал, амралтын газар,  
жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрөл олгох, сунгах тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан дөрвөн аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан дөрвөн аж ахуйн нэгжийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.

3. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан дөрвөн иргэн, аж ахуйн нэгжийн дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.


4. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг мэргэжилтэн С.Туулд үүрэг болгосугай.

5. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч П.Ариунаад даалгасугай.

ДАРГА

Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2015 оны 09 сарын 22  
өдрийн 1198 тоот тушаалын нэгдүгээр  
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН  
ЖАГСААЛТ


2015.09.14

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	ДБМБ ХХК	Титэм	Сонгинохайрхан дүүрэг, 29-р хороо, Москвагийн гудамж
2	Жо Интернэшнл ХХК	Центер	Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Содномын гудамж, 50 байр 1/1
3	Бишрэлт ХХК	Бишрэлт	Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Самбуугийн гудамж 43
4	Эб Ану ХХК	Эб	Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Консулын 13

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2015 оны 09 сарын 22  
өдрийн 408 тоот тушаалын хоёрдугаар  
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН  
ЖАГСААЛТ


2015.09.14

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Хонконглүюу ХХК	Хонконг	Сонгинохайрхан дүүрэг, 13-р хороо, Москвагийн гудамж 10/49
2	Цогт Өргөө Од ХХК	Цогт Баян	Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, Цагдаагийн гудамж
3	Болор Цэн ХХК	Эрч	Сонгинохайрхан дүүрэг, 18-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 1376
4	Кореана тайм ХХК	Кореана	Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 100

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2015 оны 09 сарын 22  
өдрийн 108 тоот тушаалын гуравдугаар  
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ АЖ АХУЙН НЭРСИЙН  
ЖАГСААЛТ

2015.09.14

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	ЭДД ХХК	Гарьд	Сонгинохайрхан дүүрэг, 8-р хороо, Баянхошууны 74
2	Эс Пи Би ХХК	Соёмбо	Сүхбаатар дүүрэг, 16-р хороо, Бэлхийн 34/04
3	Сувдан Цагаа ХХК	АСТ	Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Нарны зам
4	Иргэн Б.Бадамцэцэг	Ко Ко	Баянгол дүүрэг, 7-р хороо, Жамсранжавын гудамж 40

-ooOoo-